

**“ХУЛГАЙЛАГДСАН, ЭСХҮЛ ХУУЛЬ БУСААР ЭКСПОРТЛОГДСОН
СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ТУХАЙ ЮНИДРУА-ГИЙН КОНВЕНЦЫГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТЭЭР
ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ**

“Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн конвенцыг соёрхон батлах тухай хууль”-ийн төслийг 2003 оноос хойш ЮНИДРУА-гийн итгэмжит төлөөлөгч, Монгол Улсын ГХЯ, БСШУЯ, ХЗЯ болон хууль хяналтын байгууллагын төлөөлөгч, соёлын салбарын эрдэмтэн, судлаачдыг оролцуулан 5 удаагийн сургалт хэлэлцүүлэг хийж 237 төлөөлөл оролцсон.

№	Хэлэлцүүлгийн огноо, байршил, төлөөлөгч	Хэлэлцүүлгийн сэдэв агуулга	Хэлэлцүүлгийн үр дүн
1+ 36	ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Эрдэм шинжилгээний хүрээлэн, музей, хууль, хяналтын байгууллагын төлөөлөл нийт 35 оролцогч Улаанбаатар хот 2003-04-03	Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар	Төлөөлөгчдөөс Конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг бүрэн дэмжсэн, Монгол Улсын Засгийн газарт богино хугацаанд конвенцид нэгдэн орох талаар зөвлөмж хүргүүлсэн.
2	ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Эрдэм шинжилгээний хүрээлэн, музей, хууль, хяналтын байгууллагын төлөөлөл нийт 45 оролцогч Улаанбаатар хот 2011-07-23	“Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх үндэсний чадавх дээшлүүлэх” сургалт хэлэлцүүлэг	Төлөөлөгчдөөс Конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг бүрэн дэмжсэн, Засгийн газарт конвенцид нэгдэн орох асуудлаар дахин зөвлөмж хүргүүлсэн.
3	ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, ГХЯ, БСШУЯ, ХЗЯ /ХЗДХЯ/, Гаалийн Ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар,	“Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай” 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид Монгол Улс нэгдэн орох боломжийг	Конвенцыг соёрхон батлах тухай хууль батлуулахыг оролцогчид бүрэн дэмжсэн,

	<p>Хууль зүйн үндэсний хүрээлэн, Соёлын өвийн төв болон музейн төлөөлөлүүд ЮНИДРУА-гийн итгэмжит төлөөлөгч, Марина Шнайдер нийт 36 оролцогч</p> <p>Улаанбаатар хот 2015-06-24-нөөс 26-ны өдрүүд</p>	<p>судлах дугуй ширээний уулзалт</p>	
4	<p>Соёлын яам, Монгол Улсын Ерөнхийлөгчийн соёл, шашны зөвлөх, Цагдаагийн ерөнхий газар, Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ын Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Улс, аймгийн музей, аймаг, нийслэлийн СУГ-ийн төлөөлөл нийт 140 хүн</p> <p>Улаанбаатар хот 2022-05-05</p>	<p>“Соёлын өвийг хамгаалалт” сургалт - хэлэлцүүлэг</p>	<p>Оролцогчид Конвенцид нэгдэн орохыг бүрэн дэмжсэн,</p> <p>Конвенцид нэгдэн орох ажлыг шуурхай зохион байгуулах санал гаргасан.</p>
5	<p>Соёлын яамны СӨБХЗГ, ХЭЗХ, Гаалийн Ерөнхий газар, Нийслэлийн прокурорын газрын газар, Цагдаагийн Ерөнхий газар, Төмөр замын цагдаа, Соёлын өвийн үндэсний төв, Тагнуулийн ерөнхий газрын төлөөлөл нийт 17 оролцогч</p> <p>Улаанбаатар хот 2023-11-01-ний өдөр</p>	<p>“Соёлын өвийн мэдлэг ойлголтийг дээшлүүлэх, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг дээшлүүлэх нь” хэлэлцүүлэг</p>	<p>Оролцогчид Конвенцид нэгдэн орохыг дэмжсэн,</p> <p>Конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн яаралтай батлуулах саналыг дэвшүүлсэн.</p>

Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны

тайлан, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан, хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг зэргийг холбогдох бүх газруудад болон олон нийтэд Соёлын яамны цахим хуудсанд 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр байршуулан, ХУЛГАЙЛАГДСАН, ЭСХҮЛ ХУУЛЬ БУС... | Соёлын яам (mos.gov.mn) танилцуулсан болно.

---oO---